



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 227


Улаанбаатар хот

Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн,
ажиллах журам батлах тухай

“Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай”
Монгол улсын Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 425 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журмын 2.1.9, 2.1.10 дах заалтыг хэрэгжүүлэх
зорилгоор ТУШААХ нь:

1. "Хүний нөөцийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, "Хүний нөөцийн дэд зөвлөлийн ажиллах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Д.Оюунчимэг/-д даалгасугай.

САЙД




Н.УДВАЛ

162
Эрүүл мэндийн сайдын 2014 оны
07 сарын 07 өдрийн 177 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ХҮНИЙ НӨӨЦИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Эрүүл мэндийн сайд
Дэд дарга:	Эрүүл мэндийн яамны /ЭМЯ/ Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	ЭМЯ-ны Хүний нөөцийн удирдлага, хөгжлийн хэлтсийн нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга ЭМЯ-ны Хүний нөөцийн удирдлага, хөгжлийн хэлтсийн дарга Боловсрол шинжлэх ухааны яамны Боловсролын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлого зохицуулалтын газрын дарга Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын газрын дарга Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн боловсрол эрхэлсэн дэд захирал Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэд захирал



ДЭД ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хүний нөөцийн дэд зөвлөл (цаашид “Дэд зөвлөл” гэх) нь эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, мэргэжлийн зэрэг, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох болон эрүүл мэндийн хүний нөөцийн хөгжлийн бодлогын хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлж, бусад салбарын оролцоог хангаж, хэрэгжилтийг зохицуулж, хянаж, бодлогын зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий орон тооны бус бүтэц байна.

1.2 Дэд зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх мэргэжлийн зэрэг, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэжилтний нийгмийн баталгаа, хэрэгцээний дагуу байршуулан хуваарилах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалт бүрдүүлэхэд оршино.

1.3 Дэд зөвлөл нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, бусад холбогдох хууль, журмыг мөрдлөг болгоно.

1.4 Дэд зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж болно.

Хоёр. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагаанд шийдвэр гаргах дээд түвшний тогтвортой дэмжлэгийг олох;

2.2 Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах;

2.3 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр Салбар хоорондын шийдвэрийг гаргах.


Гурав. Дэд зөвлөлийн бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1 Дэд зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, ажлын албанаас бүрдэх ба бүтцийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.2 Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “ЭМХТ” гэх)-ийн Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын алба нь Дэд зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх)-ны үүргийг гүйцэтгэнэ.

3.3 Дэд зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх ба хурлаас шийдвэр гарна. Шийдвэр нь тухайн хэлэлцсэн асуудалтай холбоотой санал, дүгнэлт, зөвлөмж, тушаал хэлбэртэй байх ба шийдвэрт дэд зөвлөлийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчинтэйд тооцогдоно.

3.4 Дэд зөвлөл жилд хоёроос доошгүй удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.



3.5 Зөвлөлийн гишүүдийн 70-с дээш хувийн ирцээр хурал хүчинтэйд тооцогдоно. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

3.6 Хурлыг дэд зөвлөлийн дарга, түүний эзгүйд Дэд дарга даргална. Аль аль нь оролцох боломжгүй тохиолдолд хурлыг хойшлуулна.

3.7 Дэд зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд ирэхгүй тохиолдолд шалтгаанаа дэд зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргад хурал хуралдахаас 1 хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр ирүүлнэ.

3.8 Дэд зөвлөлийн гишүүнийг өөр албан тушаалтнаар орлуулахгүй.

3.9 Дэд зөвлөл нь өөрийн холбогдох асуудлаараа санал, бодлогын баримт бичиг боловсруулж, шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн үндэсний зөвлөлөөр шийдвэрлүүлнэ.

3.10 Дэд зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлд тайлагнана.

Дөрөв. Дэд зөвлөлийн даргын эрх, үүрэг

4.1 Дэд зөвлөлийн хурлын дэг, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлах;

4.2 Дэд зөвлөлийн хурлаас гарсан санал, зөвлөмжийг баталгаажуулах;

4.3 Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

4.4 Дэд зөвлөлийн үйл ажиллагааны жил тутмын санхүүжилтийн саналыг батлах;

4.5 Дэд зөвлөлийн хурлыг товлох, даргалах.

Тав. Дэд зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

5.1 Ажлын албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах;

5.2 Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулах, хурлын бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

5.3 Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулах;

Зургаа. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

6.1 Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга дэд зөвлөлийн жил тутмын төсвийг боловсруулан, дэд зөвлөлийн даргаар батлуулан ЭМХТ-ийн төсөвт тусгаж хэрэгжүүлнэ.